



ЭРҮҮЛ
МЭНДИЙН ЯАМ



ГЛОБАЛЬ САНГИЙН ДЭМЖЛЭГТЭЙ ДОХ, СҮРЬЕЭГИЙН ТӨСЛҮҮДИЙН ТАНИЛЦУУЛГА

2003-2020

УЛААНБААТАР ХОТ

ЭМЯ, ГЛОБАЛЬ САНГИЙН
ДЭМЖЛЭГТЭЙ ДОХ,
СҮРЬЕЭГИЙН ТӨСЛИЙН
ХӨТӨЛБӨР ЗОХИЦУУЛАХ НЭГЖ

 77126155, 77131328
77139732

 Э-шуудан: hiv@aids.mn

 Вэб: www.aids.mn




ЭРҮҮЛ
МЭНДИЙН ЯАМ



ГЛОБАЛЬ САНГИЙН ДЭМЖЛЭГТЭЙ ДОХ, СҮРЬЕЭГИЙН ТӨСЛҮҮДИЙН ТАНИЛЦУУЛГА

2003-2020

УЛААНБААТАР ХОТ




20,1 САЯ

ХҮНИЙГ
РЕТРОВИРУСИЙН
ЭМЧИЛГЭЭНД
ХАМРУУЛАВ.



2001 онд
Нэгдсэн үндэстний
байгууллага (НҮБ)-ын
Ерөнхий ассамблейн
чуулган дээр Ерөнхий
нарийн бичгийн дарга
асан Кофи Аннан жил
тутам 6 сая гаруй хүний
амь насанд хүрч, улс орон
бүрт нийгмийн эрүүл мэндийн
тулгамдсан асуудал болж
байгаа Дархлалын олдмол
хомсдол (ДОХ), сүрьеэ,
хумхаа өвчинтэй тэмцэхэд
зарцуулах хөрөнгө дайчлах,
өргөн цар хүрээтэй хөтөлбөр
хэрэгжүүлэх, үйл ажиллагааг
нягт уялдуулах боломжтой
шинэ механизм бүрдүүлэх
санаачлага гаргаж 2002 оны
1-р сард Женев хотноо Глобаль
сан байгуулагдсан.

Глобаль сан нь
эдийн засгийн хувьд
бага, дунд орлоготой
орнуудад санхүүгийн
дэмжлэг үзүүлэхдээ
тухайн улсын Засгийн
газраас зарцуулж
байгаа төсөв,
хөрөнгө дээр нэмэлт



санхүүжилт олгох, үр дүнд тулгуурласан санхүүжилт хийх зарчим баримталдаг.

Глобаль сангийн ДОХ, сүрьеэ, хумхаа өвчинтэй тэмцэх төслүүд нь дэлхийн 100 гаруй оронд хэрэгжиж олон сая хүний амь насыг авраад байна.



38 САЯ
ХҮНИЙ АМЬ
НАСЫГ АВРАВ.



СҮРЬЕЭГЭЭР
ӨВЧИЛСӨН
5.7 САЯ
ХҮНИЙГ ЭМЧЛЭВ.



160 САЯ

ХҮНИЙГ ХУМХАА
ӨВЧНИЙ ХАЛДВАРААС
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭВ.

Глобаль сангийн төв Швейцарь улсын Женев хотод байрладаг. Дэлхийн улс орнуудад ДОХ, сүрьеэ, хумхаа өвчинтэй тэмцэх төслүүдийг шалгаруулж, санхүүгийн дэмжлэг үзүүлдэг. Төсөл хэрэгжүүлэхэд тухайн улс орнуудад Үндэсний зохицуулах зөвлөл (ҮЗЗ), Хөтөлбөр зохицуулах нэгж (ХЗН), Сангийн орон нутгийн агент (СОНА), Салбар хүлээн авагч байгууллагууд байгуулж хамтран ажилладаг.

ҮНДЭСНИЙ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛ



ЗОРИЛГО

Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, сүрьеэгийн төслийн хэрэгжилт, оролцогч талуудын эрх тэгш байдлыг хангах, үйл ажиллагааг нь уялдуулан зохицуулах, төслийн хэрэгжилтийн явцад гарч болох аливаа эрсдэлээс сэргийлэх зорилготой.



ҮЙЛ АЖИЛЛАГАА:

Засгийн газар, Глобаль сантай ДОХ, сүрьеэ, хумхаа өвчинтэй тэмцэх асуудлаар байгуулсан гэрээ, Глобаль сангийн зөвлөмжийн дагуу тус сангийн санхүүжилтээр төсөл хэрэгжүүлэх үндсэн хүлээн авагчийг сонгон шалгаруулах, үндэсний хэмжээнд төсөл боловсруулах үйл ажиллагааг зохион байгуулах, батлагдсан санхүүжилтийн хэрэгжилтэд ерөнхий хяналт тавих, оролцогч талуудын үйл ажиллагааг нь уялдуулдаг. Үндэсний зохицуулах зөвлөл нь ажлын албатай бөгөөд тус алба нь 2 хүний бүрэлдэхүүнтэй.

САНГИЙН ОРОН НУТГИЙН АГЕНТ



ЗОРИЛГО

Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, сүрьеэгийн төслийн хэрэгжилтийг хангах, хөндлөнгийн хяналт тавих зорилготой.



ҮЙЛ АЖИЛЛАГАА:

Төслийн хэрэгжилтийг хангах, хөндлөнгийн хяналт тавьж, үйл ажиллагааны болон санхүүгийн мэдээ, тайланг хянан баталгаажуулах, үнэлгээ өгөх, дараагийн санхүүжилтийг олгох талаар санал гаргадаг.

ХӨТӨЛБӨР ЗОХИЦУУЛАХ НЭГЖ



ЗОРИЛГО

Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, сүрьеэгийн төслүүдийн үйл ажиллагааг нэгдсэн зохицуулалтаар хангах, хэрэгжилтэд хяналт тавих зорилготой.



ҮЙЛ АЖИЛЛАГАА:

Төслийн үйл ажиллагааг нэгдсэн зохицуулалтаар хангах, хэрэгжилтэд хяналт тавих, үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хагас, бүтэн жилээр нэгтгэн гаргаж, баталгаажуулан Глобаль сан, Үндэсний Зохицуулах Зөвлөл, Сангийн орон нутгийн агент, Эрүүл мэндийн яаманд тайлагнадаг.

САЛБАР ХҮЛЭЭН АВАГЧ



ЗОРИЛГО


Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, сүрьеэгийн төслийн батлагдсан төлөвлөгөөний дагуу үйл ажиллагааг хэрэгжүүлэх зорилготой.



ҮЙЛ АЖИЛЛАГАА:

Төслийн батлагдсан төлөвлөгөөний дагуу үйл ажиллагааг хэрэгжүүлж Хөтөлбөр зохицуулах нэгжид тайлагнадаг.

ТӨСЛИЙН БҮТЭЦ



ДОХ-ЫН ТӨСЛИЙН ОНЦЛОХ ҮР ДҮН (2003-2020)



Нийт хүн амын дунд
ХДХВ-ийн халдварын
тархалтыг бага
түвшинд ($<0.1\%$)
ТОГТООН БАРИХ
Мянганы хөгжлийн
6-р зорилт бүрэн
биелсэн.



Цус, цусан
бүтээгдэхүүн болон
эмнэлгийн багаж
хэрэгсэлээр
ХДХВ-ийн халдвар
ДАМЖСАН
ТОХИОЛДОЛ
гараагүй.



ХДХВ-ийн
халдвар **ЭХЭЭС**
ХҮҮХДЭД
ДАМЖСАН
тохиолдол
гараагүй.



ХДХВ-ийн халдвар
авахаас **17,723**
хүнийг, ДОХ-ын
улмаас нас барахаас
2,275 хүнийг, ХДХВ-
ийн халдвар биеэ
үнэлэгчдээр дамжин
нийт хүн амд тархахаас
сэргийлж чадсан.

СҮРЬЕЭГИЙН ТӨСЛИЙН ОНЦЛОХ ҮР ДҮН (2003-2020)



Олон эмэнд тэсвэртэй сүрьеэгийн оношлогоо, эмчилгээг анх удаа нэвтрүүлж, ХӨСҮТ-д **60**, хорих 429-р ангид **10** ортой олон эмэнд тэсвэртэй сүрьеэгийн тасгуудыг нээсэн.



Манай улс **2009** онд сүрьеэгийн тохиолдолын **85%-**ийг амжилттай эмчлэх дэлхийн зорилтод хүрсэн.



Сүрьеэгийн нас баралтын түвшинг **2,5** дахин бууруулах, тархалтын түвшинг **82%** болгох мянганы хөгжлийн 6-р зорилт бүрэн биелсэн.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ТОГТОЛЦООГ БЭХЖҮҮЛЭХ ТӨСЛИЙН ОНЦЛОХ ҮЙЛ АЖИЛЛАГАА (2010-2016)

ОНОШЛОГОО

- Цус, цусан бүтээгдэхүүнээр дамжих халдвар (ХДХВ, Гепатит В, С, тэмбүү)-ыг оношлох лабораторийн чанарын гадаад үнэлгээний хөтөлбөрийг үндэсний хэмжээнд хэрэгжүүлсэн.
- Австрали улсын Үндэсний лавлах лабораторитой хамтын ажиллагааг эхлүүлж ХӨСҮТ, ЦССҮТ-ийн Лавлах лабораториудын цус, цусан бүтээгдэхүүнээр дамжих халдварын оношлогоог олон улсын гадаад чанарын хяналтанд хамруулсан.
- Нянгийн тэсвэржилтийг тандах, хянах "WHONET" сүлжээг ХӨСҮТ, аймаг, дүүрэг, төрөлжсөн мэргэжлийн эмнэлгүүдийн нян судлалын лабораторит шинээр нэвтрүүлсэн.
- ХӨСҮТ-д эд эсийн шинжилгээний лаборатори байгуулж, шаардлагатай тоног төхөөрөмж, оношлуурыг ханган нийлүүлсэн.
- Интернетэд суурилсан лабораторийн цахим мэдээллийн сүлжээг шинээр нэвтрүүлсэн.
- ЦССҮТ-д зураасан кодын системийг нэвтрүүлсэн .

СУРГАЛТ

- Лаборатори судлал, халдвар хяналтын үндэсний сургагч багш нарыг бэлдсэн.
- Улсын хэмжээнд 21 аймаг, 9 дүүргийн эрүүл мэндийн байгууллагууд, сумын эрүүл мэндийн төвийн түвшинд "Халдвар хяналтын ажилтан"-г бэлтгэсэн.

УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ

- Анагаахын төгсөлтийн өмнөх, дараах, эмнэлгийн тусгай мэргэжилтнүүдэд зориулсан "Лаборатори судлал" цөм хөтөлбөр боловсруулан нэвтрүүлсэн.
- Анагаахын их, дээд сургуулиудын төгсөлтийн өмнөх хичээлийн хөтөлбөрт "Халдварын сэргийлэлт, хяналт-эмнэлгээс шалтгаалах халдвар"-ын цөм хөтөлбөр боловсруулан нэвтрүүлсэн.
- Халдварын сэргийлэлт, хяналтын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх, ажлын байран дахь дэмжлэгт хяналт-үнэлгээг сайжруулах дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлсэн.



ЭРҮҮЛ
МЭНДИЙН ЯАМ



ГЛОБАЛЬ САНГИЙН ДЭМЖЛЭГТЭЙ ДОХ, СҮРЬЕЭГИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

2021-2023

УЛААНБААТАР ХОТ



ТӨСЛИЙН НЭР:

“МОНГОЛ УЛСАД ХДХВ/ДОХ,
СҮРЬЕЭГЭЭС СЭРГИЙЛЭХ,
ЭМЧИЛГЭЭ, ТУСЛАМЖ
ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ
ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ
БЭХЖҮҮЛЭХ”



ЗОРИЛГО:

ХДХВ-ийн тархалт, ДОХ-той холбоотой нас баралтыг бууруулах, хүн төвтэй эрүүл мэндийн цогц үйлчилгээ үзүүлж, сүрьеэгийн тохиолдол илрүүлэлтийг нэмэгдүүлж оношлогоо, эмчилгээний шинэлэг аргуудыг нэвтрүүлж, олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэн бэхжүүлэх зорилготой.

ТӨСЛИЙН ХҮРЭХ ҮР ДҮН (2021-2023)

ОНОШЛОГОО

- 2021-2023 онд ХДХВ-ийн халдварын илрүүлэлтийг 70%-д хүргэх
- 2023 онд нийт эрчүүдтэй бэлгийн хавьталд ордог эрчүүдийн 63%, эмэгтэй биеэ үнэлэгчдийн 53%-ийг ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээнд хамруулах
- 2021-2023 онд сүрьеэгийн бүх тохиолдлын илрүүлэлтийн түвшинг 55 % хүртэл нэмэгдүүлэх
- 2021 оноос хиймэл оюун ухааны технологийг сүрьеэгийн оношлогоонд нэвтрүүлэх


ЭМЧИЛГЭЭ

- 2023 онд ХДХВ-ийн халдвартай нийт хүмүүсийн 66%-ийг Ретровирусийн эсрэг эмчилгээнд хамруулах
- 2023 онд сүрьеэгийн эмчилгээний хамралтыг 55%-д хүргэж нэмэгдүүлэх
- 2021-2023 онд сүрьеэгийн эмчилгээний амжилтыг 90%-иас дээш хадгалах
- 2023 онд сүрьеэгийн эмэнд мэдрэгжилтийн шинжилгээний хамралтыг 85%-д хүргэх
- 2021 оноос олон эмэнд тэсвэртэй сүрьеэтэй өвчтөнүүдэд явуулын тусламж үйлчилгээг нэвтрүүлэх
- 2021-2023 онд улсын хэмжээнд сүрьеэгийн илрүүлэлтэнд төр-хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлэх

УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ

- Улсын хэмжээнд эрчүүдтэй бэлгийн хавьталд ордог эрчүүдийн дундах ХДХВ-ийн халдварын тархалтыг 6,2%-иас доош тогтоон барих
- Эмэгтэй биеэ үнэлэгчдийн дундах ХДХВ-ийн халдварын тархалтыг 0%-д тогтоон барих
- Нийт хүн амын дунд ХДХВ-ийн халдварын тархалтыг 0,1%-иас доош түвшинд тогтоон барих
- 2023 гэхэд нийт эрчүүдтэй бэлгийн хавьталд ордог эрчүүдийн 70%, эмэгтэй биеэ үнэлэгчдийн 60%-ийг урьдчилан сэргийлэх хөтөлбөрт хамруулах
- 2021-2023 онд сүрьеэтэй өвчтөнүүдийн хавьтлын урьдчилан сэргийлэх эмчилгээний хамрагдалтыг 50% хүртэл нэмэгдүүлэх

ДОХ, СҮРЬЕЭГИЙН ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГУУД (2021-2023)



Халдварт өвчин
судлалын
үндэсний төв



"Монголын сүрьеэтэй
тэмцэх нийгэмлэг" ТББ



"Залуус эрүүл
мэнд төв" ТББ



"Монголын өрхийн анагаах
ухааны мэргэжилтнүүдийн
холбоо" ТББ



"Төгс бүсгүйчүүд" ТББ



ШШГЕГ-ын харъяа
хаалттай хорих
429-р анги төрөлжсөн
мэргэшлийн эмнэлэг



"Монголын сумын эмч
мэргэжилтнүүдийн холбоо"
ТББ



**For a healthy future
without TB**

"Эрүүл сүрьеэгүй
ирээдүйн төлөө"
НУТББ



Монголын улаан
загалмай нийгэмлэг



"Шинэ өөдрөг амьдрал" ТББ
(Дэд салбар хүлээн авагч)



ДОХ, СҮРЬЕЭГИЙН ТӨСЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН ЧИГЛЭЛҮҮД



ХДХВ/ДОХ, сүрьеэгээс урьдчилан сэргийлэх хөтөлбөр



ХДХВ/ДОХ, сүрьеэгийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах



ХДХВ-ийн халдвар илрүүлэх оношлогоо, үйлчилгээ



ХДХВ, сүрьеэгийн хавсарсан халдварын тусламж үйлчилгээ, урьдчилан сэргийлэх хөтөлбөр



Эрүүл мэндийн байгууллагын хүний нөөц, нийгмийн эрүүл мэндийн ажилтнуудыг чадавхижуулах хөтөлбөр



Эмэнд тэсвэртэй сүрьеэгийн тусламж үйлчилгээ



Олон нийтэд чиглэсэн сургалт, сурталчилгаа, судалгаа шинжилгээ, байгууллагын чадавхийг бэхжүүлэх, манлайллыг хөгжүүлэх



Эрчүүдтэй бэлгийн хавьталд ордог эрчүүд (ЭБЭ), эмэгтэй биеэ үнэлэгч (ЭБҮ), ХДХВ-ийн халдвартай хүмүүст чиглэсэн цогц хөтөлбөр



ХДХВ/ДОХ, сүрьеэгийн халдвартай хүмүүсийн эсрэг ялгаварлан гадуурхалт, хүчирхийлэл, гутаан доромжлолыг бууруулах



Лабораторийн мэдээллийн систем, сорьц тээвэрлэлтийн нэгдсэн сүлжээ, дэд бүтэц, тоног төхөөрөмж, чанарын удирдлагын тогтолцоо ба магадлан итгэмжлэлийн хөтөлбөр



Эрүүл мэндийн менежментийн мэдээллийн систем, хяналт-шинжилгээ, үнэлгээ



Хөтөлбөрийн менежмент

ЭМЯ, ГЛОБАЛЬ САНГИЙН
ДЭМЖЛЭГТЭЙ ДОХ,
СҮРЬЕЭГИЙН ТӨСЛИЙН
ХӨТӨЛБӨР ЗОХИЦУУЛАХ НЭГЖ

 77126155, 77131328
77139732

 Э-шуудан: hiv@aids.mn

 Вэб: www.aids.mn